

Р
РЕЗИН ЭДЛЭЛ



Манай үйлдвэр нь төрөл бүрийн резинэн эд анги үйлдвэрлэх зорилготой 2001 онд байгуулагдсан. Бид 15 жилийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулж, импортыг орлох резинэн бүтээгдэхүүний үйлдвэр, төмөр хийцийн цех, хаягдал дугуй дахин боловсруулах үйлдвэрийг ашиглалтанд оруулан ажиллаж байна.

Олон улсын стандартад нийцсэн тоног төхөөрөмж, түүхий эд ашиглан төрөл бүрийн хэмжээ, зориулалттай резинэн бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэн гаргаж байна.

Байнгын харилцаатай байдаг салбарууд



Аж үйлдвэрлэлийн салбар:

- Тоног төхөөрөмжийн жийрэг, сальник резинүүд
- Резин хийцтэй төрөл бүрийн бул
/ноос угаах, ролик резин... /
- Резинэн диафрагм, мембранууд, даавуун болон мяндсан үет резин хийцүүд гэх гэт ...



Уул уурхайн салбар:

- Алт угаах шлюзны коврик резинүүд
- Хүнд машин механизмын резин эд ангиуд
- Бүх төрлийн втулк, резин холбоос, зөөлөвчүүд
- Бүх төрлийн бутлуурын резин доторлогоо гэх гэт ...










Өргөн хэрэглээний салбар:

- Бүх төрлийн авто машины гарны втулк резинүүд
- Моторын лап болон тулгуур жийрэг резин
- Ажлын гутлын ул, өсгийний өнгө
- Төрөл бүрийн тэргэнцэрийн дугуй
- Автомашины пүршний зөөлөвч резин гэх гэт ...

АЛТ ОЛБОРЛОХ УУРХАЙД ЗОРИУЛСАН

ШЛЮЗНЫ КОВРИК РЕЗИН

ОХУ-н ТУ 2500-376-00152106-94, ТУ 38.105.376-92 техникийн нөхцлийн дагуу Монгол улсад үйлдвэрлэв.




Алтны уурхайн үндсэн болон шороон ордны тоног төхөөрөмжинд хэрэглэгддэг шлюзны резиний загвар нь олборлосон шорооны шаврын агууламж, элсний ширхэгжилт, алтны шигшигдэх шинж чанар, шлюзны хийцээс шалтгаалж олон төрөл байдаг.



Манай үйлдвэр алт олборлох уурхайн захиалгаар хамгийн түгээмэл хэрэглэгддэг, ашиглалтын үр дүн сайтай, чанарын шаардлага хангасан шлюзны коврик резинийг зориулалтын түүхий эдээр 13 дахь жилдээ үйлдвэрлэн нийлүүлж байна.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

№	Үндсэн хэмжээс			Дотор нүхний хэмжээс			
	Өргөн (мм)	Урт (мм)	Өндөр (мм)	Өргөн (мм)	Урт (мм)	Гүн (мм)	Налуу
1	600±5	800±5	10±1	10±0.1	10±0.1	6.0	90°
2	500±5	1000±5	10±1	10±0.1	10±0.1	6.0	90°
3	770±5	770±5	10±1	6±0.5	12±1	6±0.5	60°
4	490±5	790±5	10±1	10±0.1	10±0.1	6.0	90°







☎ 9917 4903
9908 0389

☑ Монгол улс, Улаанбаатар хот,
СХД, 20-р хороо, Сонсголон 18130,
Товчооны зам - 33, Резин Эдлэл ХХК

ӨРГӨН ХЭРЭГЛЭЭНИЙ БОЛОН ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН

RUBBER WHEEL CHOCKS / ДУГУЙН ИВҮҮР РЕЗИН



Хөдөлгөөнт машин механизм хязгаарлагдмал талбайд хөдөлгөөн хийх үед хана багана зэрэг хажуугийн саадыг гэмтээхээс хамгаалах, аюулгүй найдвартай зогсох байрлалыг хангах, мөргөх шүргэх үеийн цохилтын ачааллыг зөөлрүүлж бууруулах зорилгоор хэрэглэж зөөвөрлөхөд хялбар төрөл бүрийн загвар хийцтэй резинэн ивүүр, зөөлөвч, тулгуурыг үйлдвэрлэж байна.



Цэвэр резин холимогоор хийгдсэн ивүүр нь гулсамтгай, гөлгөр, тэгш гадаргуун дээр бусад материалаар хийгдсэн ижил төрлийн бүтээгдэхүүнээс зууралтын чанар хамгийн өндөр байна.



Бидний үйлдвэрлэн гаргаж буй ивүүр резин нь дараах салбаруудад өргөнөөр ашиглагдаж байна.

- Уул уурхай, хүнд машин механизм
- Тээвэр логистик, ачиж буулгах анги
- Нисэх онгоц, авиа компаниуд
- Автозасварын газрууд
- Автобус, нийтийн тээврийн салбар



РЕЗИНЭН МАНЖЕТ, КОЛЬЦО, ВТУЛК

Шингэн шахуургат тоног төхөөрөмжүүдийн нягтруулагч манжет ГОСТ 14896 - 84



D - Цилиндрин диаметр; d - Бүлүүрийн диаметр

Резинэн нягтруулагч манжет нь бүлүүрийн зарчимаар ажилладаг шингэн шахуургат төхөөрөмжийн цилиндр поршин хоёрын завсрыг жийрэглэх зориулалттай.

Ажиллах нөхцөл: Хурд: ≤ 0.5 м/с
Даралт: ≤ 50 МПа
Температур: -60°C : $+200^{\circ}\text{C}$
Давтамж: 0.5 Гц



Резинэн манжетыг хийц загвар болон ажиллах орчны даралтнаас нь хамааруулан олон төрлөөр үйлдвэрлэдэг.



МАНЖЕТНИЙ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Резиний бүлэг	2	4	6
Каучукийн төрөл	Бутадиен - нитрильный каучук		
Резиний марк	3825	ИПР-1348	В-14-1
Ажиллах температур $^{\circ}\text{C}$	-30 : $+100$	-40 : $+100$	-60 : $+100$

Шингэн шахуургат тоног төхөөрөмжүүдийн нягтруулагч хусагч манжет ТУ 38-1051725-86 / ГОСТ 6969-54







Машин тоног төхөөрөмжийн шингэн шахуургын битүүмжлэлийг хангах зориулалтаар ашигладаг.

Ажиллах температур: -30°C : $+50^{\circ}\text{C}$

РЕЗИНЭН МАНЖЕТ, КОЛЬЦО, ВТУЛК



Хийн ажиллагаатай тоног төхөөрөмжийн нягтруулагч манжет ГОСТ 6678 -72



Хийн зарчмаар ажилладаг тоног төхөөрөмжийн цилиндр бүлүүр 2-ыг нягтруулж жийрэглэх зориулалттай манжет резин. Цилиндрийг нягтруулах, бүлүүрийг нягтруулах гэсэн 2 төрлөөр үйлдвэрлэгдэнэ.

Ажиллах нөхцөл: Хурд: ≤ 1 м/с (давших, буцах)
Даралт: $0.005 \leq 1$ (МПа)
 $0.05 \leq 10$ (кгс/см²)
Температур: $-65^{\circ}\text{C} : +150^{\circ}\text{C}$


Шингэн шахуурга болон хийн ажиллагаатай төхөөрөмжүүдийн дугараг огтлолтой нягтруулагч резинэн кольцо ГОСТ 9833 - 73



Шингэн, хий, түлш, тосолгооны зарчмаар ажилладаг төхөөрөмжүүдийн хөдөлгөөнт болон хөдөлгөөнгүй холбоосуудыг нягтруулж жийрэглэх үүрэгтэй төрөл бүрийн кольцо резин. Түүхий эд нь тос, хүчил шүлт, дулаанд / $+250^{\circ}\text{C}$ хүртэл/ тэсвэртэй резин холимог байна.


РЕЗИНЭН МАНЖЕТ, КОЛЬЦО, ВТУЛК

Төрөл бүрийн цөн /втулк резинүүд/, зөөлөн холбоосууд ТУ 38.105.376-92




Цахилгаан хөдөлгүүрийн хөдөлгөөнийг дамжуулах үед хэрэглэгддэг төрөл бүрийн зөөлөн холбоос резин.

Ажиллах температур: -45°C: +70°C



Одон холбоос резинүүд ГОСТ 14084 - 93

Эргэх дамжуулгын үе дэх цилиндр голын холболт, динамик ачааллыг багасгах үед хэрэглэгддэг холбоос резинүүд



Бүлүүр голны арчигч резин манжет. ГОСТ 24811-81

Арчигч манжетийг шингэн болон хийн шахуургат цилиндрийг бохирдлоос хамгаалах зорилгоор ашигладаг.

